

(ШҮҮМЖ)

**А. А. Москалев****ГУАНСИ-ЧЖУАНСКИЙ И НИНСЯ-ХУЙЭСКИЙ  
АВТОНОМНЫЕ РАЙОНЫ КНР. М.г 1979, 151 с.**

ЗХУ болон социалист бусад орны хятадыг судлагч эрдэмтэд жил бүр хятадын судлалаар олон арван чамбай бүтээлүүдийг дотоод гадаадын уншигчдын хүртээл болгосоор байгаа билээ. Үүний нэг нь 1979 онд ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн хятадыг судлагч эрдэмтэн А. М. Москалевын бичсэн «Гуанси-Чжуанский и Нинся-Хуйэский автономные районы КНР»-(БНХАУ-ын Гуанси-Жуан болон Нинся-Хотонгийн өөртөө засах орон) хэмээх бүтээл юм. Энэ бүтээл марксизм-ленинизмийн үндэсний асуудлын сургаал дээр тулгуурлан хятадын маоист удирдлагаас хятад биш ард түмний талаар явуулж буй их хан үндэстний үндсэрхэг дээрэнгүй харгис бодлогыг эрдэм шинжилгээний гүнзгий дүгнэлттэйгээр нийгэм-эдийн засаг, улс төрийн амьдралын өнөөгийн хүрээнд авч судалснаараа онцлогтой юм.

Нэгэн сэдэвт энэ зохиол 2 бүлэг, оршил, дүгнэлтээс бүрдэж байна. Зохиолын нэгдүгээр бүлэгт: Гуанси-Жуаны өөртөө засах орны хүн ам, газар нутаг, үндэсний хувьсгалын эхний жилүүд, үндэсний асуудлын талаар баримтлах маогийнхны шовинист хандлага ширүүссэн үе, «Соёлын хувьсгал», нийгэм-эдийн засгийн байдал, 70-аад оны үе дэх Гуанси-Жуаны өөртөө засах орон гэсэн 5 хэсэг, 2-р бүлэгт: Нинся-Хотонгийн өөртөө засах орны ерөнхий байдал, Нинся-Хотонг нэгтгэхэд бэлтгэсэн нь, Нинся-Хотонгийн өөртөө засах орон 70-аад оны үед гэх зэрэг хэсгүүдээс бүрдэнэ.

Зохиогч эл номдоо Гуанси-Жуан, Нинся-Хотонгийн өөртөө засан тогтнох орны нийгэм-эдийн засаг, улс төрийн амьдралыг «Районы үндэсний өөртөө засах» гэдэг хүрээнд уугуул ард түмнийг хан үндэстний соёл, зан уламжлал, засаг захиргааны бүтцэд ойртуулан хятадчилсан маоистуудын «үндэсний бодлого» гэгчийн мөн чанарыг тод томруунаар илчлэн гаргасан байна.

БНХАУ-д ардын хувьсгал ялсан эхний 10-аад жилд Хятадын Коммунист Намаас тухайн өөртөө засах оронд (муж, хошуу, тойрог) явуулсан үндэсний нааштай бодлогын үрээр феодалын хоцрогдмол нийгэмд байсан Гуанси-Жуан, Нинся-Хотонгийн ард түмэн эдийн засаг, соёлын бүтээн босголтонд олж байсан амжилт нь дээрх өөртөө засах орныг байгуулах бодит нөхцлийг бүрдүүлж өгсөн юм гэж зохиогч дүгнэжээ (132-р тал).

Хятадад үндэстний асуудлыг шийдвэрлэх явцад ХКН-ын дотор тууштай интернационалч марксистууд зонхилж байсан 1950-иад оны үед эдгээр өөртөө засах орнууд ЗХУ-ын сэтгэл харамгүй тусламжийн үр дүнд улс орныхоо бүтээн байгуулалтанд их амжилт олж байсныг зохиогч зөв зүйтэй дүгнэсэн байна.

Харамсалтай нь 1950-иад оны сүүлчээр ХКН-ын дотор маоист жижиг хөрөнгөтний бүлэг хүчээр давамгайлж, үндэстний асуудалд үндсэр-

хэг дээрэнгүй үзлийн үүднээс хандаж үндэсний муж, хошуу, тойргийн нийгэм-эдийн засаг болон үндэсний өвөрмөц онцлогийг нь үл харгалзан, хятадын маоист удирдлага ХКН-аас үндэсний асуудалд баримталж байсан үндэстний өөртөө засан тогтнох эрхийн заалтыг таягдан хаяж «хятадын хувьсгалын практик» гэдэг халхавчийн дор «районы үндэсний өөртөө засах бодлого» гэгчийг номлож, үнэн хэрэгтээ хятад биш үндэстнүүдийг маоист цэрэг-хүнд суртлын дэглэмд тулгуурлан шууд хятадчилах арга замд шилжин орсныг зохиогч энэ номдоо тодорхой харуулсан байна (3-7-р тал). Ингэснээр эдгээр орны эдийн засаг соёлын хөгжилт мэдэгдэхүйц зогсонги байдалд орж эхлэсэн байна. Гуанси-Жуан, Нинся-Хотонгийн ард түмнийг хятадчилах бодлогодоо 1950-иад оны дундуур Өвөр Монголын өөртөө засах оронд маоистууд монголчуудад «туслах», «бат нягтралыг хүчтэй болгох» гэдэг нэрийн дор энэ орны ард түмнийг хятадчилан уусгаж эхэлсэн харгис хэрцгий үйл ажиллагаагаа «Өвөр Монголын туршлага» хэмээн эдгээр орны газар нутгийг нь хятад хүн ам олноор суудаг муж, тойргуудад нэгтгэх, хэсэгчилэн хуваах зэрэг олон янзын хорт явууллага үйлдэхдээ ашиглаж ирснийг зохиогч тодорхой баримтаар нотолжээ. (61-р тал).

Маогийнхан хятадчилан уусгах бодлогоо хэрхэн явуулж байсныг 1957 онд БНХАУ-д үндэсний асуудлыг шийдвэрлэх арга замын тухай илтгэлдээ Жоу Эньлай «Жишээлбэл, хотон болон хан ард түмэн бие биеэсээ юугаар ялгагдаж байна вэ? Бид тэднийг зөвхөн шашин шүтлэгээр нь ялгадаг» гэж хэлснийг иш татаж, (III тал) Нинся-хотонгийн бүрэлдэхүүнд Инь чу аны тойрог, учун хотон болон Гюань-хотонгийн өөртөө засах тойрог мөн Лунде, Цзань юань-хотуудыг Ганьсуд нэгтгэж, Гуанси, Гуйжоу болон Хунан мужуудын хооронд байдаг кан (дун) ястан шигүү оршин суудаг нутаг дэвсгэрийг Луншен болон Санзян-Канын өөртөө засах хошуудын хооронд хуваав. Ингэж хятадын мужуудын хуучин хил хязгаарын нэг адил нэг төрлийн хүн ам бүхий уугуул нутаг дэвсгэрийг хувааж жижигрүүлсний уршгаар олонхи хошуудад хүн амын үндэсний бүрэлдэхүүн үлэмж жигд биш болсныг жишээ баримтаар илчилжээ. (45—46-р тал).

Маогийнхны үүсгэсэн «Соёлын хувьсгал» нь үндэсний өөртөө засах бүх системд нөхөж баршгүй хохирол учруулав. «Соёлын хувьсгал»-ын явцад хятадын бусад үндэсний өөртөө засах орнуудын нэг адил Гуанси-Жуан, Нинся-Хотонд үндсэн хуулиар байгуулагдсан өөртөө засан тогтнох байгууллагууд болон мөн намын хороо, залуучуудын эвлэл, үйлдвэрчний болон бусад байгууллагуудын зөвхөн нэр нь үлдэж, газар бүхэнд удирдах тушаалыг хан үндэстний цэргийнхэн гартаа авчээ. Урьдын засаг захиргааны оронд маогийнхны диктатурын цэрэг-хүнд суртлын байгууллага «хувьсгалт хороодыг» байгуулж, бүх удирдлагыг бээжингээс зориуд илгээсэн цэргийн эрхтэн хятадуудын гарт шилжүүлжээ. Зохиогч номдоо эдгээр байгууллагуудад хан бус үндэстний төлөөлөгчдийн эзэлж буй хувийн жинг хан үндэстэнтэй харьцуулан авч үзсэн нь маоист бодлогын мөн чанарыг илчлэх бас нэгэн нотолгоо болсон байна.

«Соёлын хувьсгал»-аар тарьсан хор уршгийн улмаас өөртөө засах орны хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн зогсонги байдалд одоо хүртэл ямар нэг мэдэгдэхүйц ахиц гараагүй хэвээр байна.

70-аад оны үе болж ирэхэд маоистууд хөдөө аж ахуйд «Дажайгаас суралцах», аж үйлдвэрт «Дацингаас суралцах» (82-р тал) гэдэг лоозонгоос өөр ямар нэг дорвитой арга хэмжээ авсангүй. Энэ бүхнээс үзэхэд маоистуудын одоогийн бодлого нь эдгээр өөртөө засах орнуудад улс төр, эдийн засаг, соёлын тухай үндсэн асуудлыг өөд нь татаж чадаагүй хэвээр байна гэсэн дүгнэлтэд зохиогч хүрсэн байна (133-р тал). Өөртөө

засах эдгээр оронд хүн ам хүнсний бүтээгдэхүүнээр гачигдалтай, эмнэлэг, гэгээрлийн үйлчилгээ туйлын хангалтгүй, орчин үеийн эм хэрэглэл дутагдалтай, эмнэлгийн ажилтны хэрэгцээг «хөл нүцгэн эмч» өөрөөр хэлбэл хүн эмнэлгийн ямар ч тусгай бэлтгэлгүй хүмүүсээр нөхөхийг оролдож байна. Энэ нь маоистуудын «өөрийн хүчиндээ тулгуурлах» гэгч нь чухам ямаршуу чиг шугам болохыг харуулж байна гэж зохиогч дүгнэжээ (93-94-р тал).

А. А. Москалев номдоо 70-аад оноос «дайн д бэлтгэх» кампани хятадын хилийн Гуанси-Жуан, Нинся-Хотонгийн өөртөө засах орныг бүхэлд нь хамарч байна. Маогийнхан амьдралын бүх талыг милитарчилах явцыг өөртөө засах орон дахь хан үндэстний цэрэг-хүнд суртлын ноёрхлыг хүчтэй болгон урьд өмнө үзэгдээгүй ихээр цэрэгжүүлж энэ үндсэн дээр үйлдвэрлэл-барилгын корпусын цэрэгжүүлсэн ангиудыг өргөтгөж, энгийн хүн амыг цэргийн сургууль болон цэргийн объектуудыг барьж байгуулахад дайчлан оролцуулж, бүх нийтийг хамарсан «ардын сайн дурынхан», «өрхийн цэрэг» гэгчийн анги салбаруудад хуваарилсан нь өөртөө засах энэ орныг хэрэг дээрээ цэргийн лагерь түгшүүртэй байдлын голомт болгож байгааг (71—85-р тал) тодорхой баримт жишээгээр нотолсон байна. Ийнхүү хятад биш ард түмнийг хүчээр уусган хятадчилах, тэднийг улс төр, соёлын бүхий л салбарт ялгаварлан гадуурхаж үндэстний өөртөө засах орны системийг устгах «дарга маогийн үндэстний бодлого» гэж нэрлэгдсэн марксизм-ленинизмд шууд дайсагнасан маоист улс төрийн бодлогын уян хатан чиг шугам гэгч нь өөртөө засах орон дахь үндэстний байдал ба үндэстний бүтээн байгуулалтын явцад хэрхэн илэрч байгааг БНХАУ-ын Гуанси-Жуан, Нинся-Хотонгийн өөртөө засах орны жишээн дээр илчлэн харуулах зорилт тавьсан А. А. Москалевын энэхүү бүтээл нь хятадын доторхи хятад биш ард түмэн маоизмын улс төрийн бодлогод хэрхэн хэлмэгдсээр байгааг марксист-ленинист байр сууринаас илчлэн шүүмжилж бичсэн хятадын талаархи зөвлөлтийн эрдэмтдийн бас нэг чамбай бүтээлийн тоонд зүй ёсоор орох бүтээл болжээ.

**Ц. Баатар**